



Г.БАЯРСАЙХАН

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар: 24/10/10/1

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/842 дугаар захирамж
2	Байршил	Сансарын туннелийн авто замын засвар, шинэчлэлт (И мартаан уулзвараас туннель доогуур Их тойруу хүртэл)
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	"Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын "1"-д заасан "Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсвийн ажил (Улаанбаатар хот)" -ын хөрөнгө
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Төслөөр
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Гүүрийн бүтээцийн хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2024 он
8	Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн Замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	<ol style="list-style-type: none"> Инженер геодезийн ажлын тайлан Авто зам, замын байгууламжийн зураг төсөл Тайлбар бичиг /ажлын нэр, тоо хэмжээ, зураг төслийн иж бүрдэл, зургийн даалгавар, холбогдох захирамж гэх мэт/ Техникийн шаардлага Ажлын төсөв /магадлалаар оруулах/

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056-2009, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага" MNS 5682:2006, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, "Авто зам, замын

байгууламж. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавих ерөнхий шаардлага" MNS 5683:2022, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлааар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам", Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/456 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага" UCS 0901B:2022, UCS 0902B:2022, UCS 0903B:2022 болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх

- Геодезийн хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, зам барилгын суурь бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх тулгуур цэг байгуулах, замын төлөвлөлтийн дагуу өндрийн болон байрлалын хэмжилт хийж баталгаажуулж газрын хар өндрийг тодорхойлох
- Сансырын туслах авто замын засвар, шинэчлэлт (Сансырын колонкоос Зүүн 4 зам хүртэл зорчих хэсгийн баруун тал)*-ийн ажлын зураг төсөлтэй уялдуулах
- Авто замын үндсэн элементүүд болох авто замын зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам /төслөөр/, уулзвар төлөвлөлт, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон орчны мэдээллийг нэгтгэн боловсруулж үзүүлсэн байна.
- Хөндлөн огтлолыг орчны нөхцөлтэй уялдуулан төлөвлөх, барилга байгууламж, айлуудын орц гарцны шийдлийг оновчтой хийж хөндлөн огтлолыг төлөвлөх
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг шийдэх.
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, авто замын трассын дагууд суваг, шуудуу, жалга дайрсан үед шаардлагатай тохиолдолд гүүр эсвэл хоолойг шинэчлэх төлөвлөлтийг тусгах
- Замын хашлагыг захиалагч байгууллагатай зөвшилцэж зураг, төсөвт тусгах
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдааар зураг төсөлд тусгах
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. ЗХУТ-тэй хөдөлгөөн зохион байгуулалтын зургийг зөвшилцэх.
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх
- Шаардлагатай тохиолдолд гэрэлтүүлгийн төлөвлөлтийг хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах.
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:
 - Дэвсгэр зураг 1:500
 - Дагуу огтлол хэвтээ 1:1000
 - Босоо 1:100
 - Хөндлөн огтлол 1:100
 - Уулзвар, огтлолцол 1:500
 - Бүтээц 1:20

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтээц	1:20

- Авто замын зураг төсөл боловсруулах шатанд авто замын засвар, шинэчлэлтийн зургийг Нийслэлийн Замын хөгжлийн газартай зөвшилцөх бөгөөд шаардлагатай тохиолдолд зураг төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч зураг төслийг баталгаажуулах.
- Тухайн зам, замын байгууламжийн үндсэн элементүүдийг Нийслэлийн замын хөгжлийн газрын бүртгэл мэдээллийн сангийн бүтэц бүрэлдэхүүний дагуу мэдээллийг боловсруулж цахим хэлбэрт замын шинж чанарын мэдээллийг үүсгэж “хотын замын мэдээллийн сан”-д оруулах, баталгаажуулах /хавсралтын дагуу боловсруулах/
- Авто зам, замын байгууламжийн зураг, тайлбар бичиг, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, орчны тоймыг харуулсан зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 1ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ архивт, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.

ХЯНАСАН:

Нийслэлийн Замын хөгжлийн газрын
Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Мягмар

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Б.Анхбаяр

БОЛОВСРУУЛСАН:

НЗХГ-ын бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн

М.Ичинхорлоо

2024 оны 09 сарын 08-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗАР

Газрын байршил
Сансарын тунелийн авто зам
Газрын зориулалт
Авто зам, замын байгууламж



Таних тэмдэг

Төслийн байршил

Хянасан:
НЭХГ-ЫН Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
НЭХГ-ЫН Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мөргэжилтэн
Боловсруулсан:
НЭХГ-ЫН БТХ-ийн мэргэжилтэн

Хянасан:
НЭХГ-ЫН Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
НЭХГ-ЫН Бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мөргэжилтэн
Боловсруулсан:
НЭХГ-ЫН БТХ-ийн мэргэжилтэн

М.Ичинхорлоо / В.Мягмар /
...../Б.Анхбаяр/
...../ М.Ичинхорлоо /